Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл №12

Ажлын хэсгийн хуралдаан 2009 оны 11-р сарын 20-ны өдрийн 15 цагт Туушин ХХК-ийн байранд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн ахлагч Б.Эрдэнэсүрэн, ажлын хэсгийн гишүүд Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Төлсөн авснаа нийтэл хөтөлбөрийн зохицуулагч Д.Сэнгэлмаа, Засгийн газрын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа, Нээлттэй нийгэм форумын захирал, Үндэсний зөвлөлийн гишүүн П.Эрдэнэжаргал, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Эрдэнэбаатар, мэргэжилтэн Нүүрс ассоциацийн ажилтан Э.Сарангэрэл, Сангийн яамны Нягтлан бодох, бүртгэлийн газрын орлогч дарга Б.Ганболд, мэргэжилтэн Ш.Уртнасан, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын мэргэжилтэн н.Батбаяр, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн, Үндэсний зөвлөлийн гишүүн Б.Баярсайхан, Монголын ажил олгогч эздийн холбооны ажилтан Д.Эрдэнэбаатар, Т.Дамдинжав нар оролцов. Мөн хуралдаанд ОҮИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн ажилтан Т.Хүрэлчимэг, Коффей интернэшнл компанийн зөвлөх Жереми Вийт, Коффей интернэшнл компанийн зөвлөх Харрисон Митчелл, орчуулагч Д. Ганхуяг нар оролцов.

Танилцсан асуудал:

ОҮИТБС-ын баталгаажуулалтын урьдчилсан дүн /Коффей интернэшнл компанийн зөвлөх Жереми Вийт/

Ажлын хэсгийн хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ажлын хэсгийн ахлагч Б.Эрдэнэсүрэн нээж оролцогчдод мэндчилгээ дэвшүүлж, манай улсад ОҮИТБС-ыг баталгаажуулахаар шалгарсан Коффей интернэшнл компани урьдчилсан дүгнэлттэй танилцахаар энд цуглараад байна. Баталгаажуулагчид өөрсдийн дүгнэлтээ танилцуулна.

Коффей интернэшнл компанийн зөвлөх Жереми Вийт Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад баталгаажуулалт хийсэн урьдчилсан дүгнэлтээ танилцуулав. /Тавьсан илтгэлийг хавсаргав./

Б.Эрдэнэсүрэн-Урьдчилсан дүгнэлтээ танилцуулсан Та бүхэнд баярлалаа. Одоо асууж тодруулах зүйл болон санал байна уу?

Ш.Уртнасан: Миний хувьд та бүхнээс асуух 2 асуулт байна. Эхнийх нь Ажлын албаны чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байгаа талаар санал нэг байна. Үүнд ажлын хэсгийн оролцоо нэн чухал гэж бодож байна. Харин яаж чадавхийг бэхжүүлэх вэ гэдэг дээр та нар юу гэж бодож байна? Аудитын чанарын хяналт хийгдэх ёстой гэж дүгнэсэн байна. Энэ хаана, хэнээр хийгдэх ёстой вэ?

Жереми Вийт: Ажлын албаны чадавхийн тухайд бол техникийн болон харилцаа холбооны гэсэн 2 чиглэлээр чадавхийг дээшлүүлэх ёстой гэж дүгнэсэн байгаа. Бид гэрээ ёсоор баталгаажуулалтаа хийнэ. Чанарын хяналт гэдэг нь үүнээс гадна ямар нэгэн нэмэлт төлбөргүйгээр стратегийн чиглэлийг агуулсан тайланг нэмж гаргаж өгье гэж бодож байгаа. Тэгэхээр энэ стратегийн тайлан дээр таны 2 дахь асуултын талаар

бид дэлгэрэнгүй оруулах болно. Энд аудитаа яаж сайжруулах вэ гэх зэрэг олон асуудлыг оруулж өгнө.

Д.Сэнгэлмаа: Манайд хийгдэж байгаа аудитын тайлангууд жинхэнэ аудитын бүрэн хэмжээний, жишээ нь авлигатай холбоотой ч юм уу детальчилсан тайлан гаргаж өгөх боломжтой гэж бодож байна уу? Иргэний нийгмийн байгуулагууд энэ талаар хөндлөнгийн аудиторуудад хүсэлт тавьдаг боловч аудиторууд ийм дүгнэлт хийх нь аудитын олон улсын стандартад нийцэхгүй гэсэн тайлбар хийдэг. Энэ талаар юу гэж бодож байна вэ?

Жереми Вийт: Харамсалтай нь одоо хийгдэж байгаа аудитын тайлангийн дагуу мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулах хангалттай нарийн зүйлүүдийг хийх боломжгүй байгаа юм л даа. Жишээ нь компани тайландаа нэг тоо тавьчихаад л өөрчлөөд байна. Нигерийн жишээн дээр яръя. Анх ОҮИТБС-ын тайланг гаргахдаа аудит хийсэн компани нь маягтыг нь боловсруулаад компаниудаараа бөглүүлж авсан байдаг. Одоо бол энэ байдал өөрчлөгдсөн. Зөвхөн төлсөн татвар ч биш, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний /биет/ аудит, зарцуулалтын аудит гэх мэтээр иж бүрэн тайлан гаргадаг болсон. Энэ дэлгэрэнгүй тайлангийн дагуу авлигыг илрүүлэх болсон. Борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн тухайн үеийн үнэ, орлого, түүнээс улсад тушаасан материалаг төлбөрийг ил тод болгож байж авлига, залиланг тодорхойлох нөхцөл бүрдэнэ. Нигерт бүрэн хэмжээний аудит хийх зардал 2.0-3.0 сая доллар болж байна.

Д.Сэнгэлмаа: Манай Төлсөн авсанаа нийтэл/ТАН/ эвсэл Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмжиж, орон нутаг, олон нийтэд таниулан сурталчлах тал дээр идэвхтэй ажилладаг. Засгийн газрын болон компанийн дүнгүүд татварын албаны шат, шатны бүртгэл болон үйл ажиллагаанаас, сумын төвшин дэх бүртгэлийн сул байдал гэх мэтээс болж зөрдөг гэдгийг бид үгүйсгэхгүй байна. Гэхдээ бас бус өөр шалтгаанаас болж энэ зөрүү үүсдэг гэдгийг ил гаргах хэрэгтэй гэж бодож байна.

Б.Баярсайхан: Нэгдүгээр асуулт, би та бүхнийг Азербайжанд баталгаажуулалт хийсэн гэдгийг мэднэ. Азербайжан бол авлигын түвшин өндөртэй оронд тооцогддог. Манай улсын хувьд ч гэсэн авлигын түвшин өндөрсч байгааг олон улсын байгууллагууд олж тогтоосон. Азербайжан олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг даган мөрдөгч гэсэн статусыг авсан ч гэсэн авлигынх нь түвшин буураагүй л байгаа шүү дээ. Тэгэхээр та бүхний туршлага энэ тал дээр юу гэж зөвлөх вэ? Хоёрдугаар асуулт, баталгаажилтын нэгдсэн дүн гараагүй энэ үед, явцын дунд та бүхэн бидэнтэй энэ уулзалтыг хийх шаардлага байсан уу? Энэ уулзалтанд яригдсан зүйлүүд нь баталгаажилтын дүнд сөргөөр нөлөөлөх боломжтой юу?

Жереми Вийт: Транспаренси интернэшнлээс гаргасан судалгаан дээрх Монгол улсын авлигын индекс өсөх асуудал нь бидний баталгаажилтын тайланд нөлөөлөхгүй. Ерөнхийдөө Азербайжан болон Монгол Улсад хэрэгжиж байгаа Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын явц паралель боловч Азербайжаны нөхцөл байдал монголынхоос нэлээд ширүүн, хурцадмал асуудал гэж хэлж болохоор байсан. Тэнцсэн гэж үзэж болохгүй хэд хэдэн асуудал байсан. Баталгаажуулалтын гол зорилго бол хэн нэгний алдаа дутагдлыг олох, буруутгах, залхаан цээрлүүлэх үйл явдал биш, харин цаашид яавал илүү сайжрах вэ гэдгээ олж мэдэх явдал юм. Зарим асуудал дээр бол Монголд ч тэр, Азербайжанд ч тэр шууд хариулахад хэцүү зүйлүүд байна шүү дээ. Азербайжанд гэхэд 3 талын санамж бичиг нь ОҮИТБС-ыг орж ирэхээс өмнө батлагдсан мөртлөө, олон талын оролцоо хангагдаагүй, уг санаачилга хэрэгжиж

эхэлснээс хойш сайжирсан гэхээр зүйл харагддаггүй л юм. Илүү прагматик шийдэл олох асуудлыг авч үзэж байгаа. Азербейджанд ноцтой хүндрэл байсан.

Ш.Уртнасан: Манай улсын 2007 оны тайлан дээр гарсан зөрүүнүүдийг ерөнхийд нь харвал төлсөн татвар, ногдол ашиг, төлбөр гэсэн 3 зүйл дээр гарсан байгаа юм. Харахад байгаль орчны холбоотой зардлууд дээр хамгийн их зөрүү гараад байна. Үүн дээр ямар зөвлөмж гаргах байсан бэ?

Жеремит Вийт: Ерөнхий зөвлөмж байх байхаа, одоохондоо нарийн зөвлөмж хэлэх боломжгүй байна. Бид буцаж очоод нарийвчилсан дүгнэлтээ хийнэ. Дагаж мөрдөх стандартуудыг тодорхой бас ойлгомжтой болгох хэрэгтэй. Компаниудын зарцуулалтыг аудитлуулбал тодорхой болно.

Харрисон Митчелл: Би 12 дугаар сарын 10-нд Монголд ирж ажиллана. Харин 12 дугаар сарын 7-нд эхний байдлаар бүрэн хэмжээний тайлангаа та бүхэнд хүргүүлнэ. Цолмон гуай энэ талаар хэлэх байх.

Ш.Цолмон: Баталгаажуулагч компанитай хийсэн гэрээ ёсоор 12 дугаар сарын 10-нд Ажлын хэсгийн хуралдаанд тайлангаа оруулах ёстой гэж заасан байгаа. Тэгэхээр ирсэн тайланг орчуулаад тараана. Энэ тайлантай танилцсан талаар ажлын хэсгийн гишүүдийн саналыг аваад эцсийн тайланг гаргах ёстой. Эцсийн тайланг 12 дугаар сарын 23-нд Үндэсний зөвлөлд оруулах юм.

Б.Эрдэнэсүрэн: Бид баталгаажилтын талаар эхний байдлаар сонслоо. Ерөнхийдөө баталгаажуулагч нараас урьдчилсан байдлаар гайгүй үнэлгээ авлаа. 18 асуудлаас 5 дээр нь л жаахан бүдэрлээ. Энд хамгийн анхаарал татсан зүйл бол улс төрийн хүсэл сонирхол бага байна гэж дүгнэгдсэн явдал. 2007 оны тайланг ажлын хэсгийн хуралдаанаар 3 удаа хэлэлцсэн, ажлын хэсэг бол үнэхээр чармайлт гаргаж байгаа. Дараа 7 хоногт Үндэсний зөвлөл хуралдана. За өөр асуулт, санал байхгүй бол Баталгаажуулалтын урьдчилсан дүгнэлтээ танилцуулсан Та бүхэнд баярлалаа.

Хэлэлцсэн асуудал: ОҮИТБС-ыг сайн хэрэгжүүлж байгаа компанид өргөмжлөл олгох тухай

Б.Эрдэнэсүрэн-Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх дараагийн асуудалдаа оръё. ОҮИТБС-ыг сайн хэрэгжүүлж байгаа компанид өргөмжлөл олгох тухай асуудлыг ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулна.

Ш.Цолмон: Бид ОҮИТБС-д идэвхтэй оролцож тайлангаа жил бүр гаргаж, үнэн зөв тайлагнаж байгаа компаниуддаа өргөмжлөл гардуулах гэж байгаа билээ. Та бүхэнд ОҮИТБС хэрэгжиж эхэлснээс хойш идэвхтэй оролцсон 21 компанийн нэрсийг өгсөн байгаа. Тэгэхээр эдгээр компаниудаас ямар шалгуураар шалгаруулж өргөмжлөл олгох вэ гэдэг дээр саналаа хэлнэ үү?

Э.Сарангэрэл: Компанийг шалгаруулах нь зөв. Би Нүүрс ассоциацийг төлөөлж байгаа юм. Компаниудын хувьд Шивээ-Овоо, Эрдэс холдинг, Багануур ХК байгаль орчны нөхөн сэргээлтээ сайн хийж байгаа учир шалгаруулая гэсэн саналтай байна.

Н.Алгаа: Надад хоёр санал байна. Шим технологи компани чинь олборлолтын биш боловсруулах үйлдвэр, одоо түр зогссон байгаа тул хасах саналтай байна. Шалгуурын хувьд тайлангаа ил тод хэвлэн нийтэлсэн компаниудад л энэ шагнал очих ёстой гэж бодож байна.

Б.Баярсайхан: Шагнах гэдгийг дэмжиж байна. Шалгуурын хувьд Ашигт малтмалын хуулийн 48.10 заалтыг, 42-р зүйлийг биелүүлсэн эсэхээр нь харая. Бас тайлан гаргаж өгдөггүй компаниудад хариуцлага тооцъё. Сонин, хэвлэлд мэдээлж нэр төрд нь халдах хэрэгтэй.

Б.Ганболд: Тайлан нь ил тод, бас үнэн зөв байх гэдэг бол гол шалгуур байх ёстой, аудитын дараа зөрүү бага байх ёстой гэж бодож байна.

Н.Алгаа: Энэ санаачлага Монгол Улсад хэрэгжээд 3 жил болоход ямар ч байсан идэвхитэй оролцсон эдгээр 20 компаниудыг бүгдийг нь шагная гэсэн санал дэвшүүлье. Эхний гэсэн утгаараа зарим, дутуу дулимаг юм байсан байх. Тэгэхээр нэг их айхтар шалгуур тавиад хэрэггүй болов уу. Зүгээр сайхан урам өгөөд, бусад компаниуд бас хараад ингэдэг юм байна шүү гээд сурталчилгаа ч болно шүү дээ. Харин энэ тохиолдолд нэр нь өргөмжлөл биш батламж гэвэл зүгээр байх. Өргөмжлөл олгосноо сурталчлах хэрэгтэй.

Б.Баярсайхан: Ашигт малтмалын хуулийн 48.10 заалтыг гол болгоно шүү.

Э.Сумъяа: Зөрүү Засгийн газрын байгууллагуудын тоон дээр нэлээд гарсан байгаа. Зарим компани нь хандив, тусламж гэдэг дээрээ ч алдсан харагдсан. Би бол бүх 21 компанид өгөх саналыг дэмжиж байна. Дээр нь нэмээд Татварын ерөнхий газарт ч гэсэн өгмөөр байгаа юм. Өөрсдийн үндсэн ажлын хажуугаар энэ том тайланг улсын хэмжээгээр нэгтгэж гаргаж, Сангийн яамны нүүрийг тахалж байгаа газар шүү дээ.

Б.Эрдэнэсүрэн: Татварын байгууллага хийх ёстой юмаа л хийж байгаа шүү дээ. Хэдэн төгрөгний татвар хурааж авсан бэ гэдгээ л тооцохгүй юм бол тэгээд өөр юу хийх юм бэ? Өргөмжлөл энэ тэр өгөөд байх шаардлагагүй ээ. Тэгж хавтгайруулж бүгдэнд нь өгнө гэдгийг би дэмжихгүй байна. Энэ компаниуд дотор сайн нь ч байгаа, муу нь ч байгаа. Тэгэхээр нөгөө муу үйл ажиллагаатай, байгаль орчинд халгаатай компанид өргөмжлөл өгчихөөр тэрийг нь өөгшүүлсэн хэрэг болно. Тэгэхээр гишүүд та бүхний түрүүн хэлсэн саналын дагуу шалгуур тавьж, шигшээд хамгийн сайн үзүүлэлттэй 5 хүртэл компанийг ч юм уу шалгаруулж шагная. Харин энэ үнэлгээг хийхийг Ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга болоэ ажлын албанд хариуцуулая. Зөвшөөрч байна уу гишүүд ээ?

Хуралдаанд оролцогчид зөвшөөрөв.

Б.Эрдэнэсүрэн- Мэдээлэл болон хуралдаанд ирсэнд оролцогсдод талархал дэвшүүлэв.

Ажлын хэсгийн хуралдаан 17 цаг 30 минутад дуусав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:
Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч Б.ЭРДЭНЭСҮРЭН

Хуралдааны тэмдэглэл хөтөлсөн:
ОҮИТБС-ын Ажлын албаны ажилтан Т.ХҮРЭЛЧИМЭГ